



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 1148

Арвайхээр

### Г Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, Боловсролын тухай хуулийн 30.1.16, Засгийн газрын 2021 оны "Журам батлах тухай" 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 9 дүгээр хурлын тэмдэглэл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай" А/120 дугаар тушаал"-ын 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвартын тархалт зарим сумдад нэмэгдэж байгаатай холбогдуулан халдвар бүртгэгдсэн Арвайхээр, Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Бүрд сумдаас бусад сумдын ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар улирлын амралтыг 2021 оны 3 дугаар сарын 29-ний даваа гарагаас эхлүүлэн 2021 оны 04 дүгээр сарын 5-ны даваа гараг хүртэл амраах, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 29-ний даваа гарагаас 7 хоногийн хугацаанд түр зогсоосугай.

2. Улирлын амралт эхэлж байгаатай холбоотой дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

2.1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор танхимаар давтлага зохион байгуулах асуудлыг сумын Онцгой комисст танилцуулан нөхцөл байдлыг сайтар үнэлэн шийдвэрлүүлэн ажиллах

2.2. Ногоон бүсийн сумдын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч буй сурагчдыг цаг агаарын нөхцөл байдлыг харгалzan эцэг эх, асран хамгаалагч нарт гараас гарч хүлээлгэн өгөх, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах

2.3. Арвайхээр, Хужирт Хархорин, Бат-Өлзий сумдын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч буй сурагчдыг түргэвчилсэн болон PCR шинжилгээг авч эцэг эхчүүдэд хүргэх ажлыг зохион байгуулах.

2.4. Улирлын амралтын үеэр сурагчдад нэмэлт ачаалал үүсгэхгүй байхаар цахим болон зайн хичээлийг зохистой хэмжээнд зохион байгуулах

2.5. Хичээлийн байр, дотуур байрны орчинд ариутгал халдвартгүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар зөвлөмж чиглэлийн дагуу чанартай зохион байгуулах

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100320

D:My Doc. Zahiramj. Zasag darga